

НИТРОНИТ Э70 | ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

Бүтээгдэхүүний тодорхойлолт:

НИТРОНИТ ® Э70 Маркийн задгай эмульсийн тэсрэх бодис нь ОХУ болон Австралийн хамтарсан технологи бүхий Сибирийн эрс тэс уур амьсгалтай цаг уурын нөхцөлд хэрэглэхэд зориулагдсан бүтээгдэхүүн юм.

Зориулалт:

Нитронит Э70 эмульсийн тэсрэх бодисын техникийн нөхцөл нь М.М.Протодьяковын хэмжээсээр 20 хүртэл коэффициентийн хатуулагтай уулын цулыг бутлах ил уурхайн тэсэлгээний ажилд ашиглах зориулалттай.

Хэрэглээ:

- **Цэнэглэх цооногийн урт:** Нитронит Э70 эмульсийн тэсрэх бодис нь хамгийн ихдээ 85 м хүртэлх цооногт цэнэглэх боломжтой.
- **Цэнэглэлт:** Нитронит Э70 эмульсийн тэсрэх бодисын цооногт цэнэглэснээс 20 минутын дараа буюу хийжилтийн процесс бүрэн дууссаны дараа цооногийн түгжээс хийж болно. Нитронит Э70 эмульсийн тэсрэх бодисын цэнэглэлтийн нягтыг цооногийн диаметр, усны даралтаас (цооногийн уснаас) хамааруулж тохируулдаг.
- **Гал өгөх болон тэслэх:** Нитронит Э70 эмульсийн тэсрэх бодисыг 200мм-ээс бага диаметртэй цооногт цэнэглэх бол 400гр-тай өдөөгч, 200мм-ээс их диаметртэй цооногт цэнэглэх бол 700гр-тай өдөөгч ашиглана.
- **Сульфид хүдэрт ашиглах:** 30%-иас их пирит агуулсан сульфид болон хүдрийн ордод тэсэлгээ хийх, 4,0-өөс бага рН-тай устай цооног цэнэглэхэд “Нитронит” эмульсийн тэсрэх бодисыг бэлтгэхэд зөвхөн тогтворжуулагч нэмэгдэлтэй нитронитийн эмульсийг хэрэглэнэ.

Давуу тал:

- Устай, усгүйжүүлсэн, хуурай цооногт хэрэглэх бүрэн боломжтой.
- Тэсрэх бодисын цэнэглэлтийн хүснэгтийг батлагдсан хүснэгтийг ашиглан тэсрэх бодисын нягтыг өөрчлөх замаар чулуулгийн шинж чанар, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад тохируулан тэсрэх бодисын хүч, энергийг тохируулах боломжтой.
- Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө маш бага.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүн
Нягт,	гр/см ³	1.10 - 1.25
Хүчилтөрөгчийн тэнцэл		-0.8 - 4.8
Детонацын хурд	км/с	4.8 - 5.0
Нунтаглах чадвар	мм	24-27
Цооногийн гүн	м	85 хүртэл
Тэсрэлт авах туйлын голч диаметр	мм	70
Ажлын температур	°C	-40/+40
Устай цооногт байх хугацаа	хоног	7